



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулж,  
сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх Иргэний нисэхийн ерөнхий газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.27.1 дэх, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Тав Ди Ворлд" ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулагдах CHCNAV программ хангамжийн сургалтад Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн ахлах инженер Г.Одбаяр, шугаман өнцөг, геодезийн инженер Д.Энхтүвшин, А.Жамъяндорж нарыг тус тус хамруулсугай.

2.Сургалтад хамрагдах ажилтны суралцах хугацаанд ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Оношилгоо, хэмжил зүйн лаборатор (Г.Батцэцэг)-д, сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж, тайлан гарган Нисэхийн сургалтын төвд хүргүүлэхийг Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн ахлах инженер (Г.Одбаяр), шугаман өнцөг, геодезийн инженер (Д.Энхтүвшин, А.Жамъяндорж)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0328